



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/138

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасны дагуу хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, байгууллагуудад зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Баатардорж (Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь дарга, хурандаа)

Гишүүдэд: М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Т.Энхтөр (Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсийн ажилтан)

Б.Эрдэнэдалай (Аймгийн Цагдаагийн газрын Холбооны ахлах инженер, цагдаагийн ахмад)

Т.Болор (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ажилтан)

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Эрүүл мэндийн газрын Мэдээлэл, технологийн инженер)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Г.Түмэнжаргал (Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан)

2. Дээрх ажлыг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, байгууллагуудад зохион байгуулж, дүнг нэгтгэн 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн дотор холбогдох байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ч.Баатардорж)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН